



2009 оны тайлан



Лавлах утас:1899
www.statebank.mn



Бэн Турнбул -Гүйцэтгэх захирлын мэндчилгээ

Таны болон танай хамт олны энэ өдрийн түмэн амгаланг айлтгая !

Төрийн банк нь Монгол Улсын Засгийн Газрын 2009 оны 11 дүгээр сарын 19 -ны өдрийн хурлын тогтоолоор Монгол улсын банк санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангаж, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор 100 хувь төрийн өмчит банк болон үүсгэн байгуулагдсан арилжааны банк юм. Манай банк нь 2009 оны 11 дүгээр сарын 24 –ний өдрөөс үйл ажиллагаагаа явуулж эхлээд байна.Төрийн банк нь одоогоор 270 гаруй ажиллагсад, 28 салбар, нэгжээр дамжуулан өөрийн 110 000 гаруй харилцагчдаа банкны бүх төрлийн үйлчилгээг эрсдэлгүй, найдвартай, түргэн шуурхай хүргэж байна. Иргэдийн хувьд ил тод, нээлттэй, найдвартай гэсэн шалгуураар банкаа сонгон үйлчлүүлдэг. Тэгвэл Төрийн банк эдгээр хүлээлтийг биелүүлж чадахуйц Монгол улсын хэмжээнд тэргүүлэх / зэрэглэлийн банк болох зорилтыг тавин ажиллаж байна. Миний бие Төрийн банкны Гүйцэтгэх захирлын хувьд энэ цаг хугацаанд Монгол Улсын эдийн засагт болон банкны системд хувь нэмрээ оруулж ажиллаж байгаадаа хүндэтгэлтэй байна. Төрийн банкны удирдлагын багийг туршлагатай, урам зоригтой гадаад болон дотоодын мэргэжилтнүүдээс бүрдүүлэн ажиллаж байгаа бөгөөд харилцагч та бүхэндээ олон улсын жишигт нийцсэн банкны стандарт бүтээгдэхүүнийг санал болгон ажиллах болно. Тиймээс харилцагч та бүхэнд хамгийн эрсдэлгүй найдвартай үйлчилгээгээр ялгарах Төрийн банкны үүд хаалга үргэлж нээлттэй байх болно. Мөн манай банктай харилцан ашигтай, хамтран ажиллаж , бидний амжилтыг бүтээлцэж ирсэн нийт үнэнч, итгэлээр дүүрэн харилцагчид, түншүүд та бүхэндээ талархлаа илэрхийлж байна.

Хүндэтгэсэн,
Гүйцэтгэх захирал

Бэн Турнбул



2009 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ ТАЙЛАН ТЭНЦЭЛ

| | 2009.11.23 Аудитлагдсан /мян.төг/ | 2009.12.31 Аудитлагдсан /мян.төг/ |
|---|---|---|
| АКТИВ | | |
| Бэлэн мөнгө ба төв банк дахь харилцах | 8,000,000 | 12,047,150 |
| Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж | - | 910,128 |
| Санхүүгийн хөрөнгө оруулалт | - | 235,328 |
| Эзэл ба урьдчилгаа | - | 49,857,741 |
| Үндсэн хөрөнгө | - | 12,371,936 |
| Биет бус хөрөнгө | - | 41,637 |
| Бусад хөрөнгө | - | 62,510,394 |
| НИЙТ АКТИВ | 8,000,000 | 137,974,313 |
| ПАССИВ | | |
| Харилцагчдын харилцах, хадгаламж | - | 87,005,313 |
| Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж | - | 8,604,642 |
| Эзэлээр авсан эх үүсвэр | - | 14,830,451 |
| Бусад өр төлбөр | - | 116,747 |
| НИЙТ ПАССИВ | - | 110,557,153 |
| ӨӨРИЙН ХӨРӨНГӨ | | |
| Дүрмийн сан | 8,000,000 | 28,000,000 |
| Хуримтлагдсан ашиг(алдагдал) | - | (582,840) |
| Дахин үнзлэгээний нөөц | - | - |
| Бусад нөөц | - | - |
| НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ | 8,000,000 | 27,417,160 |
| НИЙТ ПАССИВ БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ | 8,000,000 | 137,974,313 |

2009 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН ОРЛОГО, ҮР ДУНГИЙН ТАЙЛАН

| | | |
|---|----------|------------------|
| ХҮҮГИЙН ОРЛОГО | - | 1,124,662 |
| ХҮҮГИЙН ЗАРДАЛ | - | (1,021,009) |
| ЦЭВЭР ХҮҮГИЙН ОРЛОГО | - | 103,653 |
| Хураамж ба шимтгэлийн орлого | - | 34,287 |
| Хураамж ба шимтгэлийн зардал | - | (12,577) |
| ХУРААМЖ БА ШИМТГЭЛИЙН ЦЭВЭР ОРЛОГО | - | 21,710 |
| Гадаад валютын арилжааны цэвэр орлого(зардал) | - | (24,317) |
| Үйл ажиллагааны бусад орлого | - | 384,781 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО | - | 485,827 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ | - | (514,935) |
| БОЛЗОШГУЙ ЭРСДЛИЙН САН БАЙГУУЛАХААС ӨМНӨХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ(АЛДАГДАЛ) | - | (29,109) |
| Болзошгүй эрсдлийн сангийн зардал | - | (553,732) |
| ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ(АЛДАГДАЛ) | - | (582,840) |
| Орлогын албан татварын зардал | - | - |
| ТАЙЛАНТ ҮЕИЙН ЦЭВЭР АШИГ(АЛДАГДАЛ) | - | (582,840) |

“НИЙСЛЭЛ-АУДИТ” ХХК



“NISLEL-AUDIT” Co.,Ltd

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ХЯНАЛТЫН ИТГЭМЖЛЭГДСЭН БАЙГУУЛЛАГА

Улаанбаатар хот, Сүхбаатар
дүүрэг, Бага тойруу-44
Утас/Факс 31-89-18, 70120095

Ulaanbaatar city, Sukhbaatar
district, Baga тойруу-44
Phone/Fax: 31-89-18, 70120095

Огноо 2010.03.26.

Зөрчилгүй дүгнэлт

АУДИТЫН ТАЙЛАН

ТӨРИЙН БАНКНЫ УДИРДЛАГАД

Бид Төрийн банкны 2009 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан болон мэдэгдэхүйц нягтлан бодох бүртгэлийн бодлого, тэмдэглэл, тодруулгуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь байгууллагын удирдлагын үүрэг хариуцлага байдаг. Энэхүү үүрэг хариуцлагад залилан, алдааны улмаас гарч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайланг бэлтгэх ба үнэн зөв толилуулахад холбогдох дотоод хяналтын системийг бий болгох, хэрэгжүүлэх, хадгалах, түүнчлэн нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх, тухайн нөхцөл байдалд тохирох нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх үүргүүд орно.

Аудиторын хүлээх хариуцлага

Хийж гүйцэтгэсэн аудит дээрээ үндэслэн эдгээр санхүүгийн тайлангийн талаар хараат бус дүгнэлт гаргах нь бидний үүрэг байна. Бид энэхүү санхүүгийн тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Бид танай санхүүгийн тайланг материаллаг алдаагүй бэлтгэгдсэн тухай найдвартай, хангалттай нотолгоо олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, түүнийг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС), Нягтлан бодох бүртгэлийн нийтгээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, Монгол Улсын “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль” болон холбогдох хууль, тогтоомжийг баримтлан хийж гүйцэтгэдэг болно. Эдгээр стандартууд нь санхүүгийн тайлангийн материаллаг алдаагүй эсэх талаар зохистой баталгаажуулалтыг олж авахын тулд аудитаа төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлан дахь дүн, тодруулгын дагалдах нотолгоог олж авах горимуудыг гүйцэтгэх ажил орно. Санхүүгийн тайлан нь алдаа, эсвэл залилангийн улмаас гарч болох материаллаг буруу тайлагналтай байж болох эрсдлийг үнэлэх зэрэг горимуудыг аудитор нь өөрийн шийдлээр сонгон авна. Тэдгээр эрсдлүүдийн үнэлгээг хийхдээ аудитор нь байгууллагын дотоод хяналтын системийн үр нөлөөтэй байдлын



талаар дүгнэлт гаргах зорилгоор бус, тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг зохиохын тулд санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, үнэн зөв толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг харгалзаж үздэг.

Мөн аудитын ажилд гүйцэтгэх удирдлагын хийсэн томоохон тооцоолууд ба баримталсан нягтлан бодох бүртгэлийн зарчмуудыг үнэлэх, түүнчлэн санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгад үнэлэлт өгөх ажлууд орно.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Дүгнэлт

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2009 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Төрийн банкны санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн, Монгол Улсад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан бэлтгэх заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.



2010 оны 3-р сарын 26-ны өдөр

